

Ажил олгогчийн анхааралд

Тэтгэврийн даатгал, эрүүл мэндийн даатгалын тогтолцооны тухай таницуулга

Тэтгэврийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хамрагдах нь хөдөлмөр эрхлэгчдийн амьдралд тус нэмэр болох болно.



Даатгалд хамрагдах болон зөвлөгөө авахыг хүсвэл ойролцоох JPS буюу Япон Улсын Тэтгэврийн Байгууллагад хандана уу.



日本年金機構

検索

Япон Улсын Тэтгэврийн Байгууллагын вэб сайт <https://www.nenkin.go.jp/>

Япон улсын Тэтгэврийн байгууллага нь нийтийн тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ явуулдаг.

Тэтгэврийн даатгалд хамрагдах үүргийн тухай

Дараах байгууллага нь тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдах үүрэгтэй байдаг. Үүнд: (Заавал хамрагдах байгууллага)

Бүх хуулийн этгээд аж ахуйн нэгж
(1-ээс дээш даатгуулагчтай)



Хувиараа хөдөлмөр эрхлэгч
(5-аас дээш ажилчинтай бол)




※ Хуулийн этгээд нь сургалтын байгууллага байх тохиолдолд хувийн сургуулийн багш ажилтны даатгалын нэгдсэн тогтолцоонд хамрагдана.
※ 5-аас дээш ажилтантай хэдий ч хөдөө аж ахуй, ой аж ахуй, ус болон мал аж ахуй, хууль эрхзүй зэрэг үйл ажиллагаа явуулдаг бол заавал хамрагдах үүрэгтэй нэгжид тооцогдохгүй. Заавал хамрагдах эрх үүрэггүй хуулийн этгээд ч тодорхой нөхцлийг хангасан тохиолдолд тэтгэврийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хамрагдах боломжтой байдаг. (Зөвшөөрөлтэй хуулийн этгээд)

Даатгуулагч гэдэг нь

Тэтгэврийн даатгал, эрүүл мэндийн даатгалын хувьд компани (ААН) нь зөвшөөрөгдсөн хуулийн этгээд болох бөгөөд ААН-д харьяалагдаж буй бүх хүн даатгалд хамрагдах боломжтой.


※ Тэтгэврийн даатгалд зарчмын хувьд 70 нас хүртэл хамрагдах боломжтой.



Тэтгэврийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хамрагдах нөхцөл

Үндсэн ажилтан, байгууллагын төлөөлөгч, албан хаагчид бүгд даатгуулна. Цагийн болон хуваарьт ажилтан нь үндсэн ажилтны 7 хоногийн тогтсон цаг ба 1 сарын тогтсон ажлын өдрийн 4-ний 3 хувиас илүү ажиллаж байгаа тохиолдолд даатгуулна.

Мөн үндсэн ажилтны ажлын өдрийн 4-ний 3 хувьд хүрэхгүй байсан ч, 7 хоногийн ажлын цаг нь 20 цагаас дээш байгаа тохиолдолд даатгалд хамрагдах нөхцөлд хамрагдах тул даатгуулна.



Тэтгэвэрт гарсан иргэнийг ажилд авсан тохиолдолд

70 нас арай хүрээгүй ч өндөр настны тэтгэвэр авагч (тусгай нөхөн олговрыг оруулна)-ийг ажилд авсан тохиолдолд ч, мөн адил тэтгэврийн даатгалд хамруулна.

Харин ажил эрхэлж буй хүний өндөр настны тэтгэвэр авагчийн тэтгэврийн тухайд, ажлын цалин, шагнал, урамшуулал, тэтгэвэр зэрэг 1 сарын нийт орлогын дүнтэй дүйцүүлэн, өндөр насны тэтгэврийн зарим хэсэг, эсвэл тэтгэврийн хэмжээг бүрэн олгохгүй байх тохиолдол байдаг.

Гадаад улсын иргэнийг ажилд авсан тохиолдолд

Даатгалд хамрагдах болзол хангасан иргэнийг иргэншил харгалзахгүйгээр даатгалд хамруулна.

Туршилтын хугацааны үед нийгмийн даатгалд хамрагдах байдал

Хуулийн дагуу хөдөлмөрийн гэрээ болон уг иргэний хүсэлтээс үл хамааран туршилтын хугацаа эхлэсэн өдрөөс эхлэн даатгалд хамруулна.

Даатгалд хамрагдах журам

Тэтгэврийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хамрагдах тохиолдолд ажил олгогчийн зүгээс хүсэлт гаргах хэрэгтэй.



Ажил олгогч хамрагдахад

Шинэ ажил олгогчийн хүсэлт гаргах



Даатгуулагч хамрагдахад

Даатгуулагчийн болзол хангасан тухай мэдэгдэл



Даатгуулагчид асран халамжлах хүн байгаа тохиолдолд

Асран халамжлах хүн (шилжилт хөдөлгөөн)-ий тухай мэдэгдэл

※ Мэдэгдэл, хүсэлт гаргах тухай дэлгэрэгүй мэдээллийг тэтгэврийн байгууллагаас лавлана уу.

Мөн Япон улсын Тэтгэврийн байгууллагын вэб сайтаас хүсэлт, мэдэгдэл гаргах маягтыг татаж авах боломжтой.

<https://www.nenkin.go.jp/>

Тэтгэврийн даатгал олгох тухай

Тэтгэврийн даатгал нь тэтгэврийн насанд хүрсэн тохиолдолд, хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд, нас барсан тохиолдолд, даатгуулагч нэхэмжлэл гаргаснаар тэтгэвэр болон нэг удаагийн тэтгэмж олгох тогтолцоо юм.

Тэтгэврийн насанд хүрсэн үед “Өндөр насны тэтгэвэр”

Тэтгэврийн даатгалд хамрагдсан хүнд дараах болзолыг хангасан тохиолдолд өндөр насны үндсэн тэтгэврийг бодож нэмэгдэл олгоно.

- 1 65-аас дээш насны даатгуулагч (60-аас дээш болон 66-гаас доош насны даатгуулагчдад хөрвүүлэн тооцож олгох боломжтой)
- 2 Тэтгэврийн даатгалд хамрагдсан хугацаа 1 сараас дээш байх тохиолдол
- 3 Өндөр насны үндсэн тэтгэвэр авах болзол хангахад шаардагдах хугацаа

Мөн дараах болзол хангасан 60-аас 65 насны даатгуулагчдад ажиллагсдын өндөр насны тусгай тэтгэмж олгоно.

(Төрсөн он сар өдөр, хүйсээс хамааран олгогдож эхлэх нас өөр байна.)

- 1 60 наснаас дээш
- 2 тэтгэвэрт хамрагдаж, тэтгэврийн даатгалын даатгуулсан хугацаа нь нэг ба түүнээс дээш жил байх нь
- 3 Өндөр насны үндсэн тэтгэвэр авах болзол хангахад шаардагдах хугацаа

60 нас	65 нас
Өндөр насны тусгай тэтгэмж олголт	Өндөр насны тэтгэвэр
	Өндөр насны үндсэн тэтгэвэр

Хөдөлмөрийн чадвараа алдсан үед “Хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж”

Тэтгэврийн даатгалд хамрагдаж байх хугацаанд эмнэлгийн үйлчилгээ авсан эхний өдөр, өвдсөн, бэртэл гэмтэл авсан тохиолдолд тухайн нөхцөл байдалд нийцүүлэн тэтгэвэр олгох боломжтой.

Хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж	Хөдөлмөрийн чадвараа алдсаны зэрэг 1-2-р групп Хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж болон хөдөлмөрийн чадвар алдсаны үндсэн тэтгэвэр хоёулаа олгогдоно.
Хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж	Хөдөлмөрийн чадвар алдсаны зэрэг 3-р групп Зөвхөн хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж олгогдоно.
Хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж	Хөдөлмөрийн чадвараа алдсаны 3-р группээс хөнгөн бэртэл, гэмтэл авах тохиолдол Нэг удаагийн тэтгэмж олгогдоно.


※ Тодорхой хувиас дээш даатгалын шимтгэл төлсөн хугацаа байх шаардлагатай.

Нас барсан үед “Тэжээгчээ алдсаны тэтгэвэр”

Тэтгэврийн даатгалд хамрагдаж байх хугацаандаа даатгуулагч нас барсан үе (даатгалд хамрагдсан хугацаанд эмнэлгийн үйлчилгээ авсан эхний өдрөөс эхлэн 5 жилийн хугацаанд нас барсан тохиолдол хамаарна)-д тухайн тэжээгчийн авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос хамааралтайгаар даатгуулагчийн гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгоно.

※ Даатгалын шимтгэлийг тодорхой хугацаанд төлсөн байх шаардлагатай.

- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд Тэтгэвэр олгох дараалал (Нас гэх мэт харгалзах болзолын дагуу олгоно.)
- Хүүхэдтэй гэр бүлийн хүнд, эсвэл хүүхдэд тэжээгчээ алдсаны үндсэн тэтгэврийг хамтад нь олгоно. (Нас гэх мэт харгалзах болзолын дагуу олгоно.)



Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлт, тэтгэмж авах тухай

Эрүүл мэндийн даатгал нь даатгуулагч болон түүний гэр бүлийн гишүүд (тэжээлэгч, асаргааны хүн) өвдсөн, бэртэл гэмтэл авсан (ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ бэртэл гэмтэл авах, ажилдаа ирж очих үед гамшигт өртөх тохиолдол хамаарахгүй) үед хүсэлт гаргаснаар эмчилгээний зардал болон тэтгэмж олгох тогтолцоо юм.



※ Эрүүл мэндийн даатгалд хамрагдахын тулд тодорхой болзол хангасан байх хэрэгтэй.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдах хүсэлт гаргах, зөвлөгөө авах талаар Япон улсын Эрүүл мэндийн даатгалын нийгэмлэгийн хот, орон нутгийн салбарт хандана уу.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдахад шаардлагатай бичиг баримт бүрдүүлэлт, хүсэлт гаргах, нөхөн олговрын тухай дэлгэрэнгүй мэдээллийг Япон улсын Эрүүл мэндийн даатгалын нийгэмлэгийн вэб сайтаас харна уу.

(<https://www.kyoukaikenpo.or.jp/>)

Даатгалын шимтгэл бодох аргачлал

Тэтгэврийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг даатгуулагчийн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дүнд үндэслэн дараах даатгалын хувь хэмжээгээр үржүүлэн тооцдог. Мөн бонус гэх мэт урамшууллын тухайд сар бүрийн даатгалын шимтгэлтэй ижил хэмжээгээр шимтгэлд оруулж бодно.

■ Хөдөлмөрийн хөлсний хэмжээ

- Тэтгэврийн даатгал
1-р зэрэглэл (88,000 иен)~32-р зэрэглэл (650,000 иен)
- Япон улсын Эрүүл мэндийн даатгалын нийгэмлэгийн эрүүл мэндийн даатгал
1-р зэрэглэл (58,000 иен)~50-р зэрэглэл (1,390,000 иен)

■ Бонус, урамшууллын хэмжээ

Бонус, урамшууллын мөнгөн дүнгээс 1,000 иенээс доош бутархай тоог хассан хэмжээ

■ Даатгалын шимтгэлийн хувь (Цаашид өөрчлөгдөх магадлалтай)

- Тэтгэврийн даатгал
183,00/1,000
- Япон улсын Эрүүл мэндийн даатгалын нийгэмлэгийн эрүүл мэндийн даатгал
- Шимтгэлийн хувийг засаг захиргааны нэгж, муж тус бүрээр тогтоосон байдаг. Дэлгэрэнгүй мэдээллийг Япон улсын Эрүүл мэндийн даатгалын нийгэмлэгийн хот, орон нутгийн салбараас лавлана уу.
- Хүүхдийн тэтгэмжийн мөнгө
3.6/1,000 (Ажил олгогч 100% хариуцан төлнө.)

Даатгалын шимтгэлийг ажил олгогч болон даатгуулагч хувааж төлөх ба ажил олгогч нь нийт шимтгэлийн дүнг нэгтгэн даатгалын салбарт төлнө. Нэмж дурдахад, ажил олгогч нь хүүхдийн тэтгэмж болон хүүхдийн тэтгэмж авахад шаардагдах зардлыг бүрэн төлөх шаардлагатай байдаг. (Даатгуулагч төлөхгүй.)

Дэлгэрэнгүй мэдээллийг Тэтгэврийн байгууллагын салбараас лавлаж, зөвлөгөө авна уу.